

1

**ХҮН АМЫН ХӨГЖИЛ, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2014 оны 01 сарын 15 өдөр
2014 оны 01 сарын 15 өдөр
2014 оны 01 сарын 16 өдөр

Дугаар... 4/05
Дугаар... 4/14
Дугаар... 16

Улаанбаатар хот

Журам, маягт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийг тус тус үндэслэн **ТУШААХ нь:**

1. "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын ажиллах журам"-ыг нэгдүгээр, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэлгэрэнгүй мэдээлэл" маягтыг хоёрдугаар, "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүгнэлт" маягтыг гуравдугаар, "Боловсролд хамруулах тухай шийдвэр"-ийн маягтыг дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв болон салбар комиссын үйл ажиллагааг 2014 оны 2 дугаар улирлаас эхлүүлсүгэй.

3. Хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлох, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалтын цогц хөтөлбөр боловсруулах ерөнхий аргачлалыг 2014 оны 2 дугаар улиралд багтаан боловсруулж, батлуулахыг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв /Б.Нарантуяа/-д даалгасугай.

4. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комисс болон салбар комиссын шийдвэрийг үндэслэн холбогдох арга хэмжээг шуурхай авч ажиллахыг аймаг, нийслэлийн Боловсролын газар болон Эрүүл мэндийн газар, Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст тус тус даалгасугай.


5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бүх шатны боловсролд хамруулан сургахыг боловсролын байгууллагын удирдлагуудад даалгасугай.


6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комиссын байнгын орон тоог ажиллуулах зардлыг 2014 оны батлагдсан төсөвтөө багтаан санхүүжүүлэхийг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв /Б.Нарантуяа/-д, салбар комиссын нарийн бичгийн даргаар аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газар /Д.Баярсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

7. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Хүн амын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Амарсайхан/, Боловсрол, шинжлэх ухааны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Эрдэнэчимэг/, Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Буянжаргал/-т тус тус үүрэг болгосугай.

8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв болон салбар комиссыг ажиллуулах зардлыг жил бүрийн төсөвт тусган, батлуулж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х.Мөнхзул/-д үүрэг болгосугай.

9. Комиссийн гишүүдийг давтан сургах, мэргэшүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусган, батлуулж ажиллахыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Х.Мөнхзул/-д, Боловсрол, шинжлэх ухааны яамны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Ц.Баярхүү/, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн хэлтэс /Д.Төмөрбаатар/-т тус тус үүрэг болгосугай.





**ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг хэрэгжүүлэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагааны зорилго нь хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон чадварыг илрүүлэх, тодорхойлох, тухайн хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрт тусгах арга хэмжээний ерөнхий чиглэлийг боловсруулах, тухайн хүүхдэд тохирох боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг тодорхойлж чиглүүлэх, холбон зуучлах, шаардагдах үйлчилгээнд хамруулах, үр дүнд хяналт тавихад оршино.

1.3. 2014 оны 01 дүгээр сарын 01-нээс өмнөх хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй эсэхээ аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын комиссоор тодорхойлуулсан хүүхдийн тодорхойлолт /аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын комиссын шийдвэр/ нь тухайн хүүхдийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын хурлаар шинээр орох хүртэл хугацаанд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

**Хоёр. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол,
нийгмийн хамгааллын төв комиссын удирдлага, зохион байгуулалт**

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын төв комисс (цаашид "төв комисс" гэх) нь Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн дэргэд ажиллана.

2.2. Төв комисс нь орон тооны 6 гишүүнээс бүрдэнэ. Төв комисс нь дарга, нарийн бичгийн дарга болон хүүхдийн хөгжлийн бэрхшээл, чадварыг илрүүлэх, тодорхойлох чиглэлээр мэргэшсэн сэтгэл зүйч, багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, ахуйн засалч, согог зүйч, хүүхдийн эмч, нийгмийн ажилтан зэрэг гишүүнтэй байна.

2.3. Төв комиссын даргыг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй зөвшилцөн, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө. Төв комиссын гишүүдийг эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн, төв комиссын даргатай зөвшилцөн Сэргээн засалтын хөгжлийн үндэсний төвийн дарга томилж, чөлөөлнө.

2.4. Төв комиссын дэргэд салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, төв комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудын төлөөлөл тус бүр 1 хүн, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх ашгийг хамгаалах

8

ТББ-ын болон эцэг, эхийн төлөөлөл 2 хүн, нийт 5 хүнтэй орон тооны бус зөвлөл ажиллана.

2.5. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид "салбар комисс" гэх) аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дэргэд ажиллана.

2.6. Хүн амын нягтрал, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, нарийн мэргэжилтний хангамж зэрэгтэй уялдуулан бүсийн хэмжээнд, эсхүл суманд салбар комисс байгуулан ажиллуулж болно.

2.7. Салбар комисс нь хүүхдийн хөгжлийн бэрхшээл, чадварыг илрүүлэх, тодорхойлох чиглэлээр мэргэшсэн хүүхдийн сэтгэл зүйч, багш, хэл засалч, хөдөлгөөн засалч, ахуйн засалч, согог зүйч, нийгмийн ажилтан, сэтгэцийн эмч, мэдрэлийн эмч, хүүхдийн эмч, хамт олонд түшиглэсэн сэргээн засах хөтөлбөрийн зохицуулагч зэрэг мэргэжлийн хүмүүсээс сонгон орон тооны бус 6 хүн, орон тооны 1 нарийн бичгийн даргын бүрэлдэхүүнтэй байна. Нарийн бичгийн дарга нь аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн байна.

2.8. Салбар комиссын дарга болон гишүүнийг тухайн аймаг, дүүргийн боловсролын, нийгмийн халамжийн болон эрүүл мэндийн газрын дарга, төв комиссын даргатай зөвшилцсөний үндсэн дээр аймаг, дүүргийн Засаг дарга томилно.

2.9. Төв комиссын гишүүдийн болон салбар комиссын дарга, гишүүдийн ажлын чиг үүрэг, орон тооны гишүүдийн ажлын байрны тодорхойлолтыг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн дарга батална.

2.10. Төв комисс нь жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө эрүүл мэндийн болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналд үндэслэн боловсруулж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулна. Жилийн үйл ажиллагааны тайланг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төв эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.11. Салбар комисс нь дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг тухайн оны 6 дугаар сард багтаан боловсруулж, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсвийн төслийн хамт төв комисст хүргүүлнэ.

2.12. Төв болон салбар комисс нь тогтоосон журмын дагуу хийсэн тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ. Төв болон салбар комиссын тэмдэг, хэвлэмэл хуудсыг ашиглах, хадгалах, хамгаалах зааврыг Сэргээн засалт, хөгжлийн үндэсний төвийн дарга батална.

2.13. Тухайн аймаг, дүүргийн Засаг дарга нь салбар комиссыг ажиллах байр, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах асуудлыг хариуцна. Салбар комиссыг тухайн дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж буй тусгай сургуулийг түшиглэн ажиллуулж болно.

2.14. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг

сайжруулах чиглэлээр, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд бүрэн хамруулах, хүүхэд бүрд тохирсон чанартай сургалт явуулж, боловсрол эзэмшүүлэх чиглэлээр, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон тэдний гэр бүлд нийгмийн хамгааллын болон төрөл бүрийн сэргээн засалтын үйлчилгээг чанартай хүргэх чиглэлээр төв болон салбар комисстой хамтарч ажиллан, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

Гурав. Комиссын эрх, үүрэг

3.1. Төв комисс дараах эрх, үүрэгтэй байна:

3.1.1. хүүхдийн асуудлыг салбар комиссын хурлаар хэлэлцэх үйл ажиллагаа, хүүхдийн эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн хүсэлтийг хянан шийдвэрлэх, хүүхдэд хувийн хэрэг нээх, хадгалах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүрд оношилгоо, үйлчилгээний талаарх тусгай дэвтэр нээх, түүнийг боловсруулах, ашиглах заавар, бүртгэл, мэдээлэл хөтлөх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үйлчилгээнд хамруулахаар холбогдох мэргэжлийн байгууллагад шилжүүлэх, хянах, тайлагнах асуудлыг багтаасан журам, аргачлал, заавар боловсруулж батлах;

3.1.2. салбар комиссын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, салбар комиссын гишүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалтад хамруулах, чадавхжуулах, мэдээллээр хангах;

3.1.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бүртгэл мэдээллийг улсын хэмжээнд гаргах, салбар комиссын үйл ажиллагааны тайланг нэгтгэж холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хагас, бүтэн жилд хүргүүлэх;

3.1.4. шаардлагатай тохиолдолд удирдамжийн дагуу орон нутагт ажиллах;

3.1.5. салбар комиссын гаргасан шийдвэртэй холбоотой гарсан гомдол, маргааныг хянан шийдвэрлэх;

3.1.6. Үндэслэлтэй тохиолдолд салбар комиссын шийдвэрийг хүчингүй болгох;

3.1.7. салбар комиссын гишүүд үйл ажиллагаандаа алдаа, дутагдал гаргасан нь тогтоогдсон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн бол хариуцлага хүлээлгэх, өөрчлөх талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд санал тавих;

3.1.8. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах сургалтын хөтөлбөр, стандарт боловсруулах, тусгай болон ердийн сургууль, цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг элсүүлэх, сургахтай холбогдсон журам, дүрэм боловсруулах үйл ажиллагаанд оролцох, энэ чиглэлээр санал боловсруулах.

3.2. Салбар комисс дараах эрх, үүрэгтэй байна:

3.2.1. төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;

3.2.2. хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон чадварыг илрүүлэх, тодорхойлох;

3.2.3. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрт тусгах арга хэмжээний ерөнхий чиглэлийг тодорхойлох, хөгжлийн өөрчлөлт, хөтөлбөрийн биелэлтийг хянах, эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д зөвлөгөө, мэдээлэл өгөх;

3.2.4. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын үйлчилгээнд хамруулахад дэмжлэг үзүүлэх, холбогдох байгууллагуудад холбон зуучлах;

3.2.5. салбар комиссын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж байгаа байдалд хяналт тавих, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

3.2.6. хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагыг уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхийг шаардах;

3.2.7. дүгнэлт, шийдвэр гаргахдаа тухайн хүүхдийг харьяалах нарийн мэргэжлийн эмч, багш, нийгмийн ажилтныг шаардлагатай тохиолдолд оролцуулах;

3.2.8. шаардлагатай тохиолдолд хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодруулах нарийвчилсан үзлэг, шинжилгээнд хамруулах зорилгоор холбогдох байгууллага, төв комисст хүсэлт гаргах;

3.2.9. төв комисс болон тухайн орон нутгийн захиргаа, нийгмийн халамжийн байгууллагад улирал бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, бүртгэл, мэдээллийг хүргүүлэх;

3.2.10. үйл ажиллагааныхаа тайланг төв комисст ирүүлэх.

Дөрөв. Комиссын үйл ажиллагаа

4.1. Салбар комисс нь сард 2-оос доошгүй удаа хуралдана. Төв болон салбар комиссын хурлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон тохиолдолд хийнэ.

4.2. Төв болон салбар комиссын шийдвэр нь хуралдаанд оролцсон гишүүдийн гарын үсэг зурснаар баталгаажина.

4.3. Салбар комисс нь дараах тохиолдолд хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон чадварыг илрүүлэх, тодорхойлох үйл ажиллагааг гүйцэтгэнэ:

4.3.1. эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн хүсэлтээр;

4.3.2. боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагын холбогдох мэргэжилтний гаргасан дүгнэлтэд үндэслэн тухайн хүүхдийн эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн зөвшөөрөл, хүсэлтээр;

4.3.3. асрамжийн байгууллагад асруулж байгаа хүүхдийг асрамжийн байгууллагын хүсэлтээр;

4.3.4. хараа хяналтгүй хүүхдийг тухайн аймаг, дүүргийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх нийгмийн асуудал хариуцсан хэлтсийн хүсэлтээр.

4.4. Төв комисс болон салбар комиссын хурлаар хүүхдийн асуудлыг хэлэлцэхдээ тухайн хүүхэд болон эх / эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийг заавал байлцуулна.

4.5. Төв комисс болон салбар комиссын шийдвэр нь тухайн хүүхдэд боловсрол эзэмшүүлэх, эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, усан эмчилгээ, хөдөлгөөн засал, хэл засал, ахуй засал зэрэг үйлчилгээнд хамруулах үндсэн баримт бичиг болно.

4.6. Эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ нь салбар комиссын шийдвэрийн дагуу боловсрол, эрүүл мэнд, сэргээн засалт, нийгмийн халамжийн зохих байгууллагад хандан, хүүхдийг холбогдох үйлчилгээнд хамруулна.

4.7. Салбар комисс нь хүүхдийг тусгай болон ердийн сургууль, цэцэрлэгт суралцуулах шийдвэр гаргахдаа хүүхдийн сонирхол, хүсэлтийг харгалзан, эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д танилцуулан, зөвшилцөж, зөвшөөрлийг бичгээр авна.

4.8. Салбар комисс нь аймгаас алслагдсан сум, тосгон, багт явуулын хурал хийж болно.

4.9. Салбар комиссын шийдвэртэй холбоотой маргаантай асуудал гарсан тохиолдолд эх / эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ нь төв комисст хандан шийдвэрлүүлнэ. Төв комисс гомдлыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шалгаж барагдуулна. Төв комиссын шийдвэрийг зөвшөөрөөгүй иргэн гомдлоо шүүхэд гаргаж болно.

4.10. Төв комисс нь иргэний гомдлыг барагдуулахдаа асуудлыг төв комиссын гишүүдийн хурлаар дахин магадлал хийх, шаардлагатай бол эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

4.11. Төв комисс болон салбар комисс нь бүртгэл, мэдээлэлд хяналт тавих, судалгаа, нэгдсэн дүгнэлт гаргахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаарх мэдээллийн санг ашиглана.

4.12. Төв комисс болон салбар комиссын шийдвэрийг хэвлэмэл хуудсан дээр бичих бөгөөд комиссын дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

Тав. Бусад

5.1. Сэргээн засалт хөгжлийн үндэсний төв нь төв комисс болон салбар комиссын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг үйл ажиллагааныхаа төсөвт тусгаж ажиллана.

5.2. Төв комисс болон салбар комисс нь тухайн хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг эцэслэн тогтоож, шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэрийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын байгууллагууд биелүүлэх үүрэгтэй.

12

5.3. Төв комисс болон салбар комисс нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тогтмол үзлэг, шинжилгээнд хамруулаагүй, хүүхдийн хөгжлийг дэмжих арга хэмжээ болон нийгмийн харилцаанд оруулаагүй, комиссын шийдвэрийн дагуу холбогдох үйлчилгээнд хамруулаагүй, хүүхдийн эрхийг зөрчиж байгаа эх / эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-д холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх буюу хариуцлага хүлээлгэхээр холбогдох байгууллагад санал тавих үүрэгтэй.

---oOo---

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ДӨЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд,
Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл
мэндийн сайдын 2014 оны 11/05/14 тоот
хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт

УХА0295

Эхийн мэдээлэл:																							
Ургийн овог:	Хот, аймаг, дүүрэг	Сум, хороо	Баг, хэсэг																				
Эцэг / эхийн нэр:	Гэрийн хаяг, утас:																						
Нэр:																							
Яс үндэс:	Ажлын газар, албан тушаал, утас:																						
Мэргэжил:	Боловсрол:	Гэр бүлийн байдал:	Ам бүлийн тоо:																				
		1. Гэрлэсэн 2. Цуцалсан 3. Гэрлээгүй																					
Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар:		Регистрийн дугаар:																					
<table border="1"> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td> </tr> </table>												<table border="1"> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td> </tr> </table>											
Биеийн өндөр (см)	Ердийн жин (кг)	Гэрлэсэн нас																					
Хүүхдийн мэдээлэл																							
Хүүхэд төрсөн эрүүл мэндийн байгууллагын нэр:																							
Ургийн овог:	Хүйс: эр/эм	Хүүхдийн хүйсийг заавал дугуйлан тэмдэглэ!																					

Эцэг / эхийн нэр:		Хот, аймаг, дүүрэг		Сум, хороо	Баг, хэсэг
Хүүхдийн нэр:		Гэрийн хаяг:			
Эрүүл мэндийн даатгалын дэвтрийн дугаар:				Регистрийн дугаар:	
Төрсөн он	сар	өдөр	цаг	Төрсний гэрчилгээ авсан огноо	
Үйлчилгээний төрөл	Он	Сар/ өдөр	Үргэлжилсэн хугацаа, нэмэлт тайлбар		
Халамжийн үйлчилгээнд хамрагдсан					
Боловсролын үйлчилгээнд хамрагдсан					
Сэргээн засалтын үйлчилгээнд хамрагдсан					
Эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан					
Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр			Онош, тайлбар		
Харааны бэрхшээл					
Сонсгол, хэл ярианы бэрхшээл					
Хөдөлгөөний бэрхшээл					

Оюуны бэрхшээл	
Сэтгэцийн эмгэг	
Сурах бэрхшээл	
Уналт таталт	
Эрхтэний согог, гаж хөгжил	
Удамшлын эмгэг	
Хавсарсан	
Бусад	

Комиссын хурлаар орсон огноо:

Комиссын дүгнэлт, шийдвэр

.....

.....

.....

.....

.....

.....

Комиссын хурлаар дахин орох

огноо:.....

Гарын үсэг /Хүүхдийн эх, эсхүл эцэг, асран хамгаалагч, харгалзан
дэмжигчийн/.....

.....

2. Комиссын дарга.....

3.Гишүүд:

.....

.....



.....

Комиссын дүгнэлт, шийдвэрийн биелэлтэд хяналт шинжилгээ хийгдсэн байдал

.....

.....
.....
.....
.....
.....
Хувийн хэргийн маягтыг үнэн зөв бөглөсөн аймаг/дүүргийн
комиссын нарийн бичгийн дарга...../ /

..... оны сарын өдөр



Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд,
Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл
мэндийн сайдын 2014 оны 10-р сарын 16-н тоот
хамтарсан тушаалын 3 дугаар хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН КОМИССЫН ДҮГНЭЛТ

.....онысарын.....өдөр
дүүрэг

Дугаар.....

.....аймаг, сум,

..... овогтой нь онош,
.....
чадвар алдалтыг үндэслэн
..... хөгжлийн бэрхшээлтэйг онысарын
.....өдрөөс оны сарынөдөр хүртэл
..... хугацаанд тодорхойлов.

тамга тэмдэг

Комиссын дарга /

Комиссын гишүүд /


..... /

..... /

..... /

..... /

..... /



Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд,
Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл
мэндийн сайдын 2014 оны 4/25, 4/14, 16-тоот
хамтарсан тушаалын 4 дүгээр хавсралт

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНД, БОЛОВСРОЛ,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН КОМИССЫН ШИЙДВЭР

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшүүлэх тухай

.....онысарын.....өдөр

Дугаар.....

.....аймаг, дүүрэг

Иргэн овогтой –ын/ийн

эцэг, эхийн нэр

хүсэлт гаргагчийн нэр

хүсэлтийн дагуу регистрийн дугаартай

хаягт оршин суух овогтой -

ыг/ийг ердийн/тусгай

..... сургууль/ цэцэрлэгт.....

хугацаагаар суралцуулахаар шийдвэрлэв.

Зөвшөөрсөн: Хүүхдийн эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн овог,

нэр /...../

гарын үсэг

гарын үсгийн тайлал

Эх /эцэг, асран хамгаалагч, харгалзан дэмжигч/-ийн оршин суугаа хаяг

Үндэслэл:

Хүүхдийн нийгэмших чадвар алдалтын, оюуны эсвэл хөдөлгөөний хомсдолын
хэлбэр, түвшин ба шаардагдах тусгай сургалтын хэлбэр, зохион байгуулалт,
ажлын аргачлал, хавсарсан чадвар алдалт байгаа тохиолдолд түүнийг тусгах

тамга тэмдэг

Комиссын дарга /

Комиссын гишүүд /

..... /

..... /

..... /

..... /

..... /